

# НАТО ГЭЖ ЮУ ВЭ?

Манай вэбсайтад зочилно уу.
**www.nato.int**

Умард Атлантын Гэрээний Байгууллага бол дэлхийн олон улсын томоохон байгууллагын нэг юм. Энэ нь Европ, Хойд Америкийн 30 гишүүн улсыг нэгтгэсэн улс төр, цэргийн холбоо юм.

Эдгээр улс орон аюулгүй байдал, батлан хамгаалах чиглэлээр хамтран ажиллахын тулд чуулж уулздаг. Энэ утгаараа НАТО улс төрийн болон аюулгүй байдлын хамтын ажиллагааны зорилгоор энэ хоёр тивийг хооронд нь өвөрмөц байдлаар холбож өгдөг.



## ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ

Бид аюулгүй, эдийн засгийн хувьд тогтвортой орчинд чөлөөтэй амьдарч байгаагаа ёс юм шиг боддог. Өдөр тутмын амьдралын бүх чиглэлд аюулгүй байдал бид амар амгалан, эрүүл энх байхад чухал ач холбогдолтой байдаг.

## ХАМТРАН АЖИЛЛАХ

Харилцан ярилцаж, хамтран ажиллах нь энх тайвныг эрмэлзсэн харилцаа, улс орнууд сайтар ойлголцоход нэн чухал юм.

НАТО итгэлцэл бий болгож, цаашдаа мөргөлдөөнөөс сэргийлэхэд туслахын тулд аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөх онцгой боломжийг гишүүн болон хамтран ажилладаг орнуудаа олгодог.

Бодит хамтын ажиллагаа, олон талт санаачилгаар дамжуулан улс орнууд хамтдаа аюулгүй байдлын шинэ сорилтуудтай тулгарч байна.

## ШИНЭ АЮУЛ ЗАНАЛТАЙ ТЭМЦЭХ

Аюул заналын шинж байдал өөрчлөгдөхийн хирээр энх тайвныг сахин хамгаалах арга барилыг өөрчлөх ёстой. НАТО өнөөгийн аюул заналаас хамгаалах чадавхаа өөрчлөн сайжруулж байна. Тэрээр алан хядлага, дампуурсан орнууд, үй олноор устгах зэр зэвсэг гэх мэт аюулгүй байдалтай холбоотой бусад аюул заналтай тэмцэхийн тулд зэвсэг хүчиндээ өөрчлөлт оруулж, олон улсыг хамарсан арга барилыг боловсруулж байна.

## ЭНХ ТАЙВАН, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ЦОГЦЛООХ

Тогтвортой байдлын ашиг тусыг олон тал нэгэн зэрэг хүртэх боломжтой.

Хурцадмал байдал аюулгүй байдалтай холбоотой аюул занал үүсгэж буй бүс нутгуудыг тогтворжуулах нь маш чухал юм. Тийм учир НАТО олон улсын бусад байгууллагатай хамтран хямралаас гаргах ажиллагаанд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг



# НАТО ЮУ ХИЙДЭГ ВЭ?

НАТО гишүүн орнуудаа улс төр, цэргийн арга хэрэгслээр дамжуулан хамгаалах үүрэгтэй. Тэрээр батлан хамгаалах салбарын өөрчлөн шинэчлэлт, энхийг сахиулах гэх зэрэг аюулгүй байдалтай холбоотой чиглэлээр НАТО-гийн гишүүн бус орнуудтай зөвлөлдөж, хамтран ажиллахыг мөн дэмжиж ажилладаг.

Уулзалт хэлэлцүүлэг, хамтын ажиллагаагаар дамжуулан НАТО гишүүн орнуудынхаа хил хязгаар дотор болон гадна үүссэн мөргөлдөөнөөс сэргийлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Тэрээр ардчиллын эрхэмлэх зүйлсийг сайшаан дэмжиж, мөргөлдөөнийг тайван аргаар шийдвэрлэхийн төлөө ажилладаг. Хэрэв дипломат хүчин чармайлт гаргаад үр дүнд хүрэхгүй бол тус байгууллага дангаараа эсвэл бусад орнууд, олон улсын байгууллагуудтай хамтран хямралаас гаргах, энхийг сахиулах ажиллагаа хэрэгжүүлэх цэрэг байлдааны чадавхтай.

НАТО иргэний онцгой байдлын үед авах арга хэмжээг төлөвлөх, гамшигтай тэмцэхэд нь Холбоотнууд, хамтран ажилладаг байгууллагуудад туслах, мөн шинжлэх ухаан, байгаль орчны чиглэлээр хамтын ажиллагаа өрнүүлэх чиглэлийн үйл ажиллагаанаас бүрдсэн гурав дахь чиглэлээр ажилладаг.

# НАТО ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?

Гишүүн улс бүр Бельгийн Брюссель хот дахь НАТО-гийн улс төрийн төв байранд байнгын төлөөлөгчтэй байдаг. Үүнийг тус Холбооны зөвлөлдөх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд засгийн газраа төлөөлөн суудаг элчин сайд тэргүүлдэг.

Хойд Атлантын Зөвлөл бол тус байгууллагын хэмжээнд хамгийн чухал улс төрийн шийдвэр гаргадаг бүлэг мөн. Тус зөвлөл янз бүрийн түвшинд хуралддаг бөгөөд чухал асуудлаар санал нэгдэхэд нь гишүүддээ тусалдаг НАТО-гийн Ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүлдэг.

НАТО-ийн хороо бүрийн бүх шийдвэрийг санал нэгтэйгээр гаргадаг. Тиймээс “НАТО-гийн шийдвэр” бол бүх гишүүн орнуудын хамтын хүсэл зорилгын илэрхийлэл байдаг.

НАТО өөрийн гэсэн маш цөөн, байнгын бие бүрэлдэхүүнтэй. Хойд Атлантын Зөвлөл аливаа ажиллагааг баталж зөвшөөрсний дараа гишүүд сайн дураараа бие бүрэлдэхүүн илгээдэг. Ажиллагаа дууссаны дараа эдгээр бие бүрэлдэхүүн өөр өөрийн улс руугаа буцдаг.

Цэргийн командлалын бүтэц энэ ажиллагааг зохицуулж хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Энэ бүтэц янз бүрийн гишүүн орнуудад байрласан штаб, баазуудаас бүрддэг.

НАТО-гийн өдөр тутмын үйл ажиллагаа, иргэний болон цэргийн барилга байгууламж, аюулгүй байдлын хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийг гишүүн орнуудын засгийн газар зардал хуваахаар харилцан тохиролцсон хувь хэмжээгээр бүрдүүлдэг хамтын төсвөөс санхүүжүүлдэг.



# ГИШҮҮН БОЛОН ХАМТРАН АЖИЛЛАДАГ ОРНУУД

**1949 оны 4-р сарын 4-нд Хойд Атлантын гэрээнд гарын үсэг зурсан.**

### ГИШҮҮН ОРНУУД (+ЭЛССЭН ОН)

- Албани - 2009
- Америкийн Нэгдсэн Улс - 1949
- Бельги - 1949
- Болгар - 2004
- Бүгд Найрамдах Чех Улс - 1999
- Герман - 1955
- Грек - 1952
- Дани - 1949
- Исланд - 1949
- Испани - 1982
- Итали - 1949
- Их Британи - 1949
- Канад - 1949
- Латви - 2004
- Литви - 2004
- Люксембург - 1949
- Монтенегро - 2017
- Нидерланд - 1949
- Норвеги - 1949
- Польш - 1999
- Португал - 1949
- Румын - 2004
- Словак - 2004
- Словени - 2004
- Турк - 1952
- Унгар - 1999
- Франц - 1949
- Хойд Македони - 2020
- Хорват - 2009
- Эстон - 2004

### ЭЭНХ ТАЙВНЫ ТӨЛӨӨ ТҮНШЛЭЛИЙН ОРНУУД (ЭТТО)

- Австри
- Азербайжан
- Армен
- Беларусь
- Босни Герцеговин
- Бүгд Найрамдах Молдов Улс
- Гүрж
- Ирланд
- Казахстан
- Киргизстан
- Мальта
- Орос
- Серби
- Тажикстан
- Туркменистан
- Узбекистан
- Украйн
- Финлянд
- Швед
- Швейцар

### ГАЗАР ДУНДЫН ТЭНГИСИЙН ОРНУУДЫН ХОЛБОО (ГДТОХ)

- Алжир
- Египет
- Израиль
- Йордан
- Мавритан
- Марокко
- Тунис

### ИСТАМБУЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНААЧИЛГЫН ОРНУУД (ИХАСО)

- Арабын Нэгдсэн Эмират
- Бахрейн
- Катар
- Кувейт

### ДАЯН ДЭЛХИЙН ТҮНШҮҮД

- Австрали
- Афганистан
- Бүгд Найрамдах Солонгос Улс
- Ирак
- Колумб
- Монгол
- Пакистан
- Шинэ Зеланд
- Япон

0351-20 © NATO 2020 - MONG